



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2021 оны 05 болон 06 дахь долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 02-р сарын 08-наас 02-р сарын 18-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 3 дахь дугаарыг хүргэж байна.

1

### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Цар тахлын улмаас АНУ-ын ажилгүйдэл өндөр түвшинд байна.** “АНУ-ын Конгресс 1.9 их наяд долларын нэмэлт төсөв баталвал ажилгүйдлийн түвшин 2022 онд гэхэд цар тахлаас өмнөх түвшинд эргэн очиж, ажиллах хүчин хэвийн горимд эргэн орох боломжтой” гэж АНУ-ын Сангийн сайд Жанет Йеллен мэдэгдлээ. Хөдөлмөрийн статистикийн товчооноос мэдэгдсэнээр ажилгүйчүүдийн 40 шахам хувь нь сүүлийн 6 сарын туршид ажилгүй байсан бөгөөд өмнөх оны 2-р сартай харьцуулахад ажиллагсдын тоо 9 сая орчмоор буураад байгааг мэдээлжээ. Тус улсын ажилгүйдлийн түвшин 2021 оны 1-р сарын байдлаар 6.3 хувь байв. Жанет Йеллен нэмэлт төсвийн дэмжлэггүйгээр ажилгүйдлийн түвшинг эргүүлэн 4 хувьд хүртэл бууруулахад 4-5 жил шаардагдахаар байгааг онцоллоо.
- **“АНУ-ын төсвийн алдагдал 2021 онд 2.3 их наяд ам.долларт хүрэх төсөөлөлтэй байна”** гэж Конгрессын төсвийн албанаас мэдээлэв. Энэ нь Ерөнхийлөгч Жо Байдены дэвшүүлсэн эдийн засгийг дэмжих 1.9 их наяд долларын нэмэлт төсвийг тооцоогүй дүн юм. Төсвийн алдагдлын төсөөлөл нь 2020 оны төсвийн алдагдал (3.1 их наяд ам.доллар)-аас бага боловч цар тахлын өмнөх үетэй харьцуулахад том дүн юм. Тодруулбал, 2020 онд төсвийн алдагдал ДНБ-ийн 14.9 хувийг эзэлж байсан бол 2021 онд 10.3 байхаар байна. АНУ-ын өрийн хэмжээ 2031 он гэхэд 35.3 их наяд ам.долларт хүрч, Өр/ДНБ харьцаа түүхэн дээд хэмжээнд буюу 107 хувьд хүрч өсөх магадлалтай байна. АНУ-ын Конгрессын төсвийн албанаас тус улсын эдийн засаг 2021 онд 3.7 хувиар өсөхөөр төсөөлж байгаа нь ХНБ-ны төсөөлөл (4.2 хувь)-аас 0.5 нэгж хувиар бага байна.
- **“Их Британийн эдийн засаг 2020 онд 9.9 хувиар буюу түүхэндээ хамгийн ихээр агшлаа”** гэж тус улсын Үндэсний статистикийн газраас мэдээлэв. Гэсэн хэдий ч 2020 оны 10-аас 12-р сарын хооронд эдийн засаг 1 хувиар өссөн нь энэ онд агшилт буурах, өсөлт бий болох найдлагыг төрүүлж байна. “2021 оны эхний улиралд хөл хориотой холбоотойгоор эдийн засгийн идэвхжил буурах хэдий ч, I улирлаас хөл хорио сулрахын зэрэгцээ

вакцинжуулалтын хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэж эхлэх төлөвтэй” байгааг тус улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны үндэсний хүрээлэнгийн ахлах эдийн засагч Кемар Уайт мэдээлэв.

- **Японы эдийн засаг 2020 оны сүүлийн улиралд хүлээлтээс 3.2 нэгж хувиар өндөр буюу 12.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.** Өсөлтөд экспорт өсч, бизнесүүдийн хөрөнгө оруулалт сайжирсан нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн, Засгийн газраас хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих багц арга хэмжээнүүд гол нөлөөг үзүүлсэн гэж эдийн засагчид үзэж байна. Гэвч КОВИД-19-ийн тархалттай холбоотойгоор дахин онц байдал зарлаад байгаагаас эдийн засгийн сэргэлт энэ улиралд удааширч магадгүй байгаа аж. Цаашид вакцинжуулалт эхэлж, цар тахлын тархалтыг хяналтдаа авбал эдийн засаг тогтвортой сэргэх хүлээлттэй байна.
- European Commission байгууллагаас 2021 оны 2-р сарын 21-нд нийтэлсэн “2021 оны эдийн засгийн төлөв” тайланд **Евро бүсийн эдийн засаг 2021 онд 3.7 хувь, 2022 онд 3.9 хувиар өсөх төсөөллийг гаргажээ.** Мөн өмнөх улиралд төсөөлж байсантай харьцуулахад бүсийн эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд өмнөх төсөөллөөс илүү богино хугацаанд очихоор байгааг онцоллоо. 2020 оны 3-р улиралд Евро бүсийн эдийн засаг сэргэж эхэлсэн ч цар тахлын хоёр дахь давлагаа эхэлж, хөл хорио тогтоосноор 4-р улиралд эргээд агшив. Хөл хорио зарим улсад үргэлжилж байгаагаар холбоотойгоор энэ оны эхний улиралд бүсийн эдийн засаг агших төсөөлөлтэй байна. Харин вакцин хийгдэж, хөл хорио сулармагц 2021 оны зунаас эдийн засаг өсч эхэлнэ гэж таамаглажээ. Үүний зэрэгцээ дэлхийн эдийн засгийн

төсөөлөл сайжраад байгаа нь бүсийн эдийн засгийн төлөвт эерэг нөлөө үзүүлэхээр байна. Тайланд дурдсанаар Евро бүсийн инфляцын түвшин 2020 онд 0.3 хувь байсан бол 2021 онд 1.4 хувь болж өсөх төлөвтэй байна.

- **“Түүхий эдийн үнийн шинэ супер цикл эхэлсэн байж магадгүй”** гэж “JPMorgan Chase & Co.” байгууллагаас онцолжээ. Энэ нь сүүлийн үед хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ огцом өсч, металлын үнэ сүүлийн жилүүдийн хамгийн өндөр түвшинд хүрч, нэг баррель газрын тосны үнэ 50 ам.доллараас даваад байгаагаар холбоотой юм. “Эдгээр үнийн өсөлт нь цаг уурын өөрчлөлтийн эсрэг газрын тосны нийлүүлэлтийг хязгаарлах, сэргээгдэх эрчим хүчний дэд бүтцийг байгуулахтай холбоотойгоор металлын эрэлт нэмэгдэх зэргээс шалтгаалсан байх магадлалтай” гэж JPMorgan Chase & Co-ийн эдийн засагч Марко Колановик шинжээчээр ахалсан эдийн засагчдын баг үзэж байна. “Өнгөрсөн жил унаад байсан газрын тосны үнэ сэргэж, огцом унасан газар тариалангийн бизнес идэвхжээд байгаа нь дараагийн түүхийн эдийн үнийн супер цикл эхэлсэн болохыг илтгэж байж болзошгүй” гэж Марко Колановик хэлжээ. Энэ нь сүүлийн 100 жилийн 5 дахь супер цикл болох бөгөөд хамгийн сүүлийнх нь БНХАУ-ын эдийн засгийн огцом өсөлттэй холбоотой байсан байна. Харин энэ удаагийн цикл цар тахлын дараах улс орнуудын сэргэлт, төв банкуудын маш зөөлөн мөнгөний бодлого, сул ам.долларын ханш, инфляц болон дэлхий даяар байгаль орчны илүү чанга хатуу бодлого зэрэг нь нөлөөлнө гэж үзжээ.
- **ОХУ-ын Төв банк 2021 оны 2-р сарын 12-ны мөнгөний бодлогын хурлаар бодлогын хүүгээ 4.25 хувьд хэвээр үлдээлээ.** 2020 оны 12 болон



2021 оны 1-р сард эрэлт хүлээлтээс өндөр байж, харин нийлүүлэлт тал дээр зарим хязгаарлалт байгаагаас үнийн өсөлтөд дарамт үзүүлсэн хэвээр байгааг онцолжээ. Төв банк инфляцын 2021 оны төсөөллөө 3.7-4.2 хувьд байхаар өсгөөд байгаа бөгөөд цаашид мөнгөний бодлогын өнөөгийн байдлыг харгалзан

жилийн инфляц 4 орчим хувьд хүрнэ гэж үзэж байна. Өрх, аж ахуйн нэгжүүдийн инфляцын хүлээлт өндөр хэвээр байна. Вакцинжуулалт болон зарим улс орнуудын нэмэлт төсвийн дэмжлэг нь санхүүгийн болон түүхий эдийн зах зээл дээрх үнийн өсөлтөд нөлөөлж байгааг мөн дурджээ.

### Эх сурвалж:

1. CNBC, [Yellen says U.S could return to full employment next year if Congress passes \\$1.9 trillion stimulus](#)
2. CNBC, [Deficit projected at \\$2.3 trillion for 2021, not counting additional stimulus, CBOs says](#)
3. BBC, [UK economy suffered record annual slump in 2020](#)
4. Aljazeera, [Japan's economy performed better than expected in last quarter](#)
5. Bloomberg, [JPMorgan Says Commodities May Have Just Begun a New Supercycle](#)
6. Bank of Russia, [The Bank of Russia keeps the key rate at 4.25% p.a](#)
7. European Commission, [Winter 2021 Economic Forecast : A challenging winter, but light at the end of the tunnel](#)

## 2

## БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- ӨМӨЗО 2021 оны 1-р сард 95.3 сая тонн нүүрс олборлосон нь өмнөх оны мөн үеэс 25 хувиар нэмэгдсэн үзүүлэлт байв. Өвөр Монголын нүүрс олборлогч компаниуд үйлдвэрлэлээ ийнхүү 4 сар дараалан 93 сая тонноос дээгүүр хадгалснаар БНХАУ-ын нүүрсний зах зээлд нийлүүлэлт тогтвортой үргэлжлэх нөхцөл болж байна. Цагаан сарын үеэр нийлүүлэлтээ тогтвортой хадгалахын тулд жилийн нийт 860 сая тонны хүчин чадалтай ойролцоогоор 200 нүүрсний уурхайг хэвийн горимоор ажиллуулах шийдвэр гаргасан нь 2-р сарын эхэн үед нийлүүлэлтийн дийлэнхийг бүрдүүлэх үүрэгтэй 76 цахилгаан станцын нөөц 11 сая тонн буюу 17 хоногийн хангалттай нөөцийн түвшинд хүрэхэд нөлөөлөв.
- Цагаан сарын дараа БНХАУ-ын зах зээл дээрх коксжих нүүрсний үнэ баярын өмнөх үеийн түвшинд

тогтвортой хадгалагдсан бөгөөд цаашид ган үйлдвэрлэгчдийн идэвхжил

өндөр байдаг 4-5 сараас өмнө богино хугацаанд нүүрсний үнийг төдийлөн нэмэгдүүлэхгүй байх хүлээлттэй. Харин дэлхийн зах зээл дээрх коксжих нүүрсний үнэ Энэтхэгийн гангийн үйлдвэрүүдийн өндөр эрэлтийн нөлөөгөөр нэмэгдээд байна.

- БНХАУ-ын хойд мужуудын нэг Шаанси мужийн хүрэн нүүрсний нөөц 2-р сарын 19-ны өдрийн байдлаар 5.44 сая тонн хүрч цагаан сарын өмнөх үеэс 7.41 хувиар нэмэгдэв. Тус нөөцийн хэмжээ 5 сая тоннд тогтвортой хадгалагдаж байсан бол 1-р сарын дунд үеэс хойд мужуудын боомт дээрх нөөц нэмэгдсэн нөлөөгөөр хурдтай өсчээ. Цаашид хүйтний улирал дуусч буй нийлүүлэлт тогтвортой байх хүлээлттэй тул үнэ богино хугацаанд нэмэгдэхээргүй байна.



- **БНХАУ-ын албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс 12-р сард 51.9 байсан бол 2021 оны 1-р сард хүлээлтээс багаар өсч 51.3-д хүрэв.** Түүнчлэн экспортод суурилсан Caixin боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс 12-р сард 53 байсан бол 2021 оны 1-р сард хүлээлтээс буурч 51.5 хүрлээ. Үүний зэрэгцээ албан ёсны боловсруулах бус үйлдвэрлэлийн индекс 12-р сард 55.7 байсан бол 1-р сард хүлээлтээс багаар 52.4 буюу 2020 оны 3-р сараас бага түвшинд хүрч буурав. Үйлдвэрлэлийн PMI индекс ийнхүү хүлээлтээс ихээр буурахад Ковид-19-ийн халдварын тоо нэмэгдсэн нөлөөгөөр Хэбэй, Жилин, Хелонгжианг зэрэг мужуудад хөл хорио тогтоож, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт саатсан болон гадаад эрэлт буурсантай холбоотой экспортын захиалгын хэмжээ 50.2 буюу өмнөх оны 8-р сараас

**Эх сурвалж:**

хойших бага түвшинд хүрсэн зэрэг нь голлон нөлөөлөв. Гэсэн хэдий энэ нь түр зуурын шинжтэй, барууны орнуудад үндэсний томоохон баярууд болж өнгөрсөнтэй холбоотой байж болзошгүйг Блүүмбергийн шинжээчид онцолж байна. Харин үйлдвэрлэлийн салбар дахь компаниудыг хэмжээгээр нь авч үзвэл том, дунд ААН-үүдэд тэлэлт хадгалагдсан хэдий ч хурдац нь удааширсан бол жижиг ААН-үүдэд агшилт үргэлжлэв. Үйлдвэрлэлийн бус PMI индекс буурахад өвлийн саруудад ажиглагддаг барилгын салбарын бага идэвхжил, өмнөх жилүүдээс хүйтэн өвөл болж буй, Ковид-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсэнтэй холбоотойгоор хэрэглээний өсөлт суларсан болон шинэ захиалгын тоо 48.7-д буюу 2020 оны 3-р сараас хойших анх удаа агшсан нь голлон нөлөөлөв.

1. *China React: PMIs show economy hit winter virus speed bump, Bloomberg*
2. *SXcoal, Inner Mongolia's Jan coal output increases 25% YoY to 95.32 Mt*




3

### МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2021/02/16	Өөрчлөлт				YoY	
		daily	weekly	monthly	year to date		
<b>Зэс</b>	8424	0.0%	1.5%	6.1%	7.4%	45.3%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ өндөр түвшинд хадгалагдахад нөлөөлж байна.
<b>Төмрийн хүдэр</b>	159	0.0%	5.7%	-2.1%	4.5%	109%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлттэй тул төмрийн хүдрийн эрэлт сайн байх төлөв, өвлийн саруудад идэвхжил нэмэгдсэнтэй холбоотойгоор үнэ нэмэгдэв.
<b>Алт</b>	1794	-0.1%	-2.7%	-2.7%	-7.8%	11.9%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал бүрэн буураагүй, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. Гэсэн хэдий ч улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн гэсэн мэдээ зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны үнэ буурахад нөлөөлөв.
<b>Газрын тос (Брент)</b>	63	0.3%	3.4%	16.1%	24.4%	10.2%	КОВИД-19-ийн тархалт нэмэгдэж байгаатай нь газрын тосны үнийг бууруулах чиглэлд нөлөөлж байна. Олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байна. Харин АНУ-ын төв мужуудад цаг агаар эрс хүйтэрч, олборлолт саатсанаар нийлүүлэлт 30 гаруй хувиар буурсан нөлөөгөөр үнэ нэмэгдэв.

Зураг 1. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ

